




ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

Д. Ангар
Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
Монголын Хөрөнгийн Бирж



Монголын хөрөнгийн зах зээлд оролцож буй хүн амын оролцоо


Манай улсын хувьд хүн ам цөөтэй, хөрөнгийн зах зээлийн талаархи боловсрол мэдлэг иргэдийн дунд бага байгаагаас үүдэн зах зээлийг ойлгож, түүнээс ашиг хүртэх, хөрөнгө оруулалт хийх аргачлалд төдийлөн сайн суралцаагүй байна.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

Нийт арилжаанд оролцож буй иргэдийн хувьд

Арилжаанд оролцож байгаа дотоодын хөрөнгө оруулагчдыг арилжаа хийж буй үнийн дүнгээр нь авч үзвэл **жижиг хөрөнгө оруулагч** дөнгөж **8%** -ийг л эзлэж байгаа бол **92%** -ийг **байгууллагын буюу том хөрөнгө** оруулагчид эзэлж байна.



ᠨᠢᠶ᠋ᠲᠤ ᠠᠷᠢᠯᠵᠢᠠᠨᠳᠤ ᠣᠷᠣᠯᠴᠣᠵᠢᠢᠨ ᠪᠤᠢ ᠶᠢᠷᠭᠡᠳᠢᠶᠢᠨ ᠬᠤᠪᠦᠳᠤ

Хөрөнгө оруулагчдыг бэлтгэх

Байгууллагын хөрөнгө оруулагч

- Зах зээлийг идэвхижүүлэгч Market maker –ийг бэлтгэх
- Зах зээлд оролцогчдыг төрөлжүүлэх шаардлагатай (Stock broker, bond trader, commodity trader, day trader)
- Хөрөнгө оруулагчдад ХЗЗ-ийн төлбөртэй мэдээллийг цогц үйлчилгээ үзүүлэгч аж ахуй байгуулах
- Бүтээгдэхүүний нэр төрлийг бий болгох (Зах зээл үргэлж өсөлтөөс ашиг олдог биш, уналтаас хэрхэн ашиг олж болох уу? үүсмэл санхүүгийн хэрэгсэл)

Жижиг хөрөнгө оруулагч

- Олон нийтэд чиглэсэн богино, дунд хугацааны танхимын сургалтыг зохион байгуулах
- Боловсролын системд ХЗЗ-ийн сургалт хөтөлбөрийг тусгаж оруулах
- ХЗЗ-ын оролцоог дэмжсэн уралдаан тэмцээнийг зохион байгуулах (Онлайн арилжаатай зохиомол арилжаа хийх уралдаан тэмцээн)

Бусад дэд бүтэц

- Дотоодын зээлжих зэрэглэл тогтоох



Хөрөнгө оруулагчдад хувьцааны зах зээлийг таниулах

- Хөрөнгийн зах зээлд анхлан суралцагсдад зориулсан сурах бичгийг гаргах, олон нийтийн хүртээл болгох
- ТВ-ийн сувгуудаар хөрөнгийн зах зээлийн талаар сонирхолтой цуврал нэвтрүүлэг, хичээл явуулж эхлэх
- Хүмүүсийг туршилтаар бодит бус мөнгөн дээр арилжаанд оролцох бололцоог бүрдүүлэх онлайн арилжааны системтэй болох
- Арилжаанд оролцох механизмыг хялбаршуулж, цахим арилжааны системийг нэвтрүүлэх, зах зээлийг бодитоор мэдрэх боломжийг хөрөнгө оруулагчдад олгох ажлыг зохион байгуулах
- Хөрөнгө оруулагчдын хооронд хувьцааны сонголт хийх шийдвэр гаргахад мэдээлэл солилцох, олж авсан мэдээллийг бусадтай хэлэлцэх, арилжааны туршлагаа хуваалцах цахим хуудас бий болгох
- Хүүхэд залуус, зах зээлд оролцогчдыг идэвхижүүлэх тэднийг зах зээлд татан оролцуулах мөн чанарыг нь таниулах зорилготой ТББ, арилжааны клубыг олноор бий болгоход дэмжлэг үзүүлж ажиллах



Хөрөнгө оруулагчдад бондын зах зээлийг таниулах

Хөрөнгө оруулагчид яагаад Бондын захыг сонирхдог вэ


- Хувьцааг бодоход эрсдэл багатай, тогтмол өгөөж өгдөг зах зээл
- Хөрөнгө оруулагчидад банкны хадгаламжаас өндөр өгөөж өгч чадна,
- Эрсдэлгүйн бондын хувьд хөрвөх чадвар сайн
- Хөрөнгө оруулагчдад зөвхөн бондын хүүгийн орлогын талаар ойлгуулан тайлбарлахаас гадна, бондын зах зээлд ашиг олж **болох арилжааны тактик** арга хэрэгслийг эзэмшүүлэх асар өндөр ач холбогдолтой ажил.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДАД
БОНДЫН ЗАХ ЗЭЭЛИЙГ
ТАНИУЛАХ



Зах зээлийн үзүүлэлт


2014.10.31 –ны байдлаар



Сүүлийн 12 жилтэй харьцуулж харахад 33Ү нь 2004 оны байдлаар \$24,800,000 –с \$831,707,458 болж өссөн бөгөөд

2014.10.31 Дотоодын нийт бүтээгдэхүүний 9.4 % ийг эзлэж байна. Өнгөрсөн хугацаанд 2011 онд 18.02 % 2004 онд 1.24% ийг эзлэж байсан .

2014,11,07 **TOP-20 index** 15,311.52 нэгж болж хаагдсан. 2014 оны байдлаар дээд : 17,160.49, дундаж : 15,883.40 хамгийн бага : 14,686.48 in 2014.



ӨНГӨРСӨН ХУГАЦААНД
 2011 ОНД 18.02 %
 2004 ОНД 1.24% ИЙГ ЭЗЛЭЖ БАЙСАН .



Хөрөнгө оруулагчдыг татах бусад орны туршлага (АНУ)

АНУ-ын насанд хүрэгчдийн 50% нь ямарваа нэгэн компанийн хувьцааг эзэмшдэг.

- Их орлогтой /жилийн 70,000 ам.доллараас их/ насанд хүрэгчдийн **80%**
- Дунд орлогтой /жилийн 30-70,000 ам.долларын хооронд/ насанд хүрэгчдийн **50%**
- Бага орлогтой /жилийн 30,000ам.доллараас бага/ насанд хүрэгчдийн **20%**

АНУ-ын хүн амын хөрөнгийн хадгалалт.
Нийт Хөрөнгө: 63.9 Их наяд ам.доллар



Хөрөнгө оруулагчдыг татах бусад орны туршлага

Хөрөнгө оруулагчдыг татах бусад орны туршлага (Их Британи)

- Англи улс хөрөнгө оруулагчдад зориулсан хөтөлбөрийг төр, санхүүгийн салбар, иргэний нийгмийн байгууллагуудын боловсруулсан хөтөлбөрийн дагуу хөрөнгө оруулагчдад санхүү, хөрөнгө оруулалтын боловсролыг олгодог байна. Үүнд:

Байгууллагын нэр	Хөтөлбөрийн нэр
Санхүүгийн үйлчилгээний зөвлөл	Санхүүгийн чадамжийг сайруулах үндэсний стратеги
Засгийн газар	Засгийн газрын хөтөлбөр
Санхүүгийн боловсролын холбоо	Хүүхэд залуус, насанд хүргэгчдэд зориулсан хөтөлбөр
Санхүүгийн үйлчилгээний институт	Хувь хөрөнгө оруулагчдын хөтөлбөр
Иргэдийн зөвлөл	Онцгой хөтөлбөр

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

- Гадаад орнуудын стратеги, хөтөлбөрүүдийг харьцуулан харахад гол төлөв хөрөнгө оруулагчдад мэдлэг олгох, боловсролыг дээшлүүлэх зорилгоор дараах 6 чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажилладаг байна. Үүнд:
 1. Засгийн газрын хөтөлбөр,
 2. Хөрөнгө оруулалтын үндэсний стратеги
 3. Хүүхэд залуус, насанд хүрэгчдийн хөтөлбөр,
 4. Мэргэжлийн байгууллагын хөтөлбөр,
 5. Гадаадын хөрөнгийн бирж дэх хувь хөрөнгө оруулалчдын мэдээлэл
 6. Онцгой хөтөлбөр

Эдгээр нь санхүүгийн зах зээлийн талаар өндөр мэдлэг боловсролыг хөрөнгө оруулагчдад өгч, үүгээр дамжуулан түүний гэр бүл эцэг эхчүүдэд нь энэ талаархи ойлголт мэдээллийг хүргэх замаар зах зээлийн оролцогчдыг нэмэгдүүлдэг байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

"Санхүүгийн болон хөрөнгө оруулагчдын боловсрол" хөтөлбөр

Улс орон	Хөтөлбөрүүд
Argentina	Programs for Individual Investors
Australia	National Strategy for Financial Literacy Programs by Governments Programs by Government Regulator Programs for Individual Investors
Brazil	Programs by Government Regulator Programs for Individual Investors Information for Individual Investors on Foreign Exchange (FOREX)
Canada	Programs by Government Regulators Programs for Children and Young Adults Special Focus Programs Information for Individual Investors on Foreign Exchange (FOREX)
Channel Islands, Jersey	Programs by Government Regulators
France	Program by Government Regulator Programs for Individual Investors Information for Individual Investors on Foreign Exchange (FOREX)
Germany	Programs for Individual Investors
Hong Kong	Information for Individual Investors on Foreign Exchange (FOREX)
India	Programs for Individual Investors

Улс орон	Хөтөлбөрүүд
Japan	Program by Government Regulator Programs for Individual Investors Special Focus Programs
South Korea	Programs for Children and Young Adults Programs for Individual Investors Special Focus Programs
Sweden	Programs for Individual Investors Special Focus Programs
United Kingdom	National Strategy for Financial Capability Programs by Governments Programs for Children/Young Adults Programs for Individual Investors Special Focus Programs
United States	National Strategy for Financial Literacy Programs by Governments Programs by Government Regulators Programs for Children/Young Adults Programs for Individual Investors Special Focus Programs Information Related to Scams, Frauds, Investor Alerts Information for Individual Investors on Foreign Exchange (FOREX)
Multilateral Organizations	Information for Individual Investors on Foreign Exchange (FOREX)



Монгол - Хөрөнгө оруулагчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр

Монгол иргэдийн хөрөнгийн зах зээл хөрөнгө оруулах үйл ажиллагааны талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх үүднээс МХБ-ийн зүгээс дунд хугацааны төлөвлөгөө боловсруулан ажиллана. Энэхүү төлөвлөгөө нь үндсэн 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Үндэсний стратеги боловсруулах

- Хөрөнгө оруулагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх үндэсний стратегийг санаачлан боловсруулах
- Холбогдох байгууллагуудад санал хүргүүлэх

Хөрөнгийн биржийн дунд хугацааны хөтөлбөр боловсруулах

- Хөрөнгийн биржийн сургалтыг төрөлжүүлэн зорион байгуулах
- Зөвлөгөө зааврыг тогтмол өгөх
- Улирал, сарын сэтгүүлийг хэвлэн нийтэх

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Үндэсний стратегийн ерөнхий бүтэц

Бүх нийтэд санхүүгийн зах зээлийн мэдлэг, боловсрол оргох үндэсний стратегийг боловсруулан дэмжүүлэх

Хөтөлбөрт Их, Дээд сургуулиудын хичээлийн төлөвлөгөөнд санхүүгийн боловсрол хичээлийг суулгаж өгөх

Хичээлийн хөтөлбөр, заах арга зүйг тодорхой болгох,

Албан бус сургалтын хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах,

Зайн сургалтын хөтөлбөр боловсруулах, аудио, видео, кино хичээлийг бэлтгэх, радио, телевизийн нэвтрүүлгийг бий болгох

Санхүүгийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх, тогтвортой ажиллагааг хангах шаардлагатай

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

МХБирж ТӨХК-ийн цаашид хийгдэх шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ

- Засгийн газрын 2013 оны 41 тогтоолыг хэрэгжүүлэхээр Сангийн яамнаас ЗГ-ын өрийн хэрэгслийг МХБиржээр дамжуулан явуулж эхэлсэн.
- Хөрөнгө оруулагчдад өөрийн гар утаснаас ханшийн мэдээллээ хүлээн авах боломжийг олгосон Мобайл апплейкшн зохион бүтээсэн
- Зах зээлд жижиг дунд бизнесийг дэмжих, тэднийг зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэх боломжийг нээсэн 3 – дагч самбарыг шинээр гаргасан.
- 2014 оны 8-р сард СЗХ-оос дотоодын анхны кастодиан банкинд тусгай зөвшөөрлийг олгосон.
- FX Futures and Options** – Дотоодын зах зээлд хөрөнгө оруулагч гадаадын хөрөнгө оруулагчдад учирдаг нэгтом эрдсэл бол валютын эрсдэл байдаг. Үүнийг зөв зохистой удирдах боломжийг гаргаж өгөхийн тул Валютын фьючерсийг нэвтрүүлэх чиглэлд ажлын хэсэг гарч туршилтаар нэвтрүүлж эхлэхээр бэлтгэж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

Анхаарал тавьсанд баярлалаа

ᠠᠨᠬᠠᠶᠢᠷᠠᠯ ᠲᠠᠪᠦᠰᠠᠩᠳᠠ ᠪᠠᠶᠢᠷᠯᠠᠯᠠᠭ᠎ᠠ

